

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАЙЛАН
2023 оны сүүлийн хагас

Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн хараат бус гишүүн Ж.Дэлгэрсайхан

Миний бие тус банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн, 2021 оны 2 сараас аудитын хорооны дарга, эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр ажиллаж байна.

Монголбанкнаас баталсан “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ын 5.1-д заасны дагуу өөрийн ажлыг тайлагнаж байна.

2023 оны 2-р хагас жилд ТУЗ-ийн, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон байдал:

Хүснэгт 1. Хуралд оролцсон байдал

д/д	Хурал, оролцсон ажлууд	Огноо	Оролцсон хэлбэр	Хэлэлцсэн асуудал
1	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зохион байгуулалт	2023.07.06	Цахим	<ul style="list-style-type: none"> Хурлын бүртгэлийг өөрчлөх тухай асуудалд санал өгөх
2	Аудитын хорооны хурал	2023.07.20	Цахим	<ul style="list-style-type: none"> “ХХБ-ны 2023 оны II улирлын санхүүгийн тайлан”-гийн танилцуулга
3	ТУЗ-н хурал	2023.08.10	цахим	<ul style="list-style-type: none"> ТУЗ-н даргыг сонгох ТУЗ-н дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг сонгох “ХХБ”ХК-нийн 2023 оны эхний хагас жилийн тайлан
4	Аудитын хорооны хурал	2023.08.30	Цахим	<ul style="list-style-type: none"> “ХХБ-ны 2023 оны санхүүгийн тайланд аудит хийх байгууллагыг сонгох “ДАГ-ын 2023 оны II улирлын ажлын тайлан”-гийн танилцуулга
5	Эрсдэлийн удирдлагын хорооны хурал	2023.10.04	Цахим	<ul style="list-style-type: none"> Бодлого, журам, зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, журам, сэжигтэй гүйлгээтэй холбоотой журмууд харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаатай холбоотой журмуудын шинэчлэл
6	ТУЗ-н хурал	2024.10.09	Цахим	<ul style="list-style-type: none"> Сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай (Си Эн Би Консалтинг ХХК); Сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай (Ти Ди Би Лизинг ХХК); ХХБ-ны Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой бодлого, журам, зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай; Худалдаа, хөгжлийн банкны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай.

7	ТУЗ-н ээлжит хурал	2023.10.19	Цахим	<ul style="list-style-type: none"> Худалдаа хөгжлийн банк ХК-ийн 2023 оны 3-р улирлын гүйцэтгэл; Банкны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх, зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тайлан.
	Эрсдэлийн удирдлагын хорооны хурал	2023.10.23	Цахим	<ul style="list-style-type: none"> Худалдаа, хөгжлийн банкны 2023 оны Чанаргүй зээлийг бууруулах стратегийн 3 дугаар улирлын гүйцэтгэл; Худалдаа, хөгжлийн банкны 2023 оны Эрсдэлийн аппетитын 3 дугаар улирлын гүйцэтгэл.
8	Аудитын хорооны хурал	2023.10.28	Цахим	<ul style="list-style-type: none"> ДАГ-аас: “ДАГ-ын ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний загвар” танилцуулга, ДАГ-аас: “ДАГ-ын 2023.03 улирлын ажлын тайлан”-гийн танилцуулга.
	ТУЗ-н ээлжит бус хурал	2023.11.20	Саналын хуудсаар	<ul style="list-style-type: none"> Зээлийн өр төлбөрт тооцон авч, Худалдаа, хөгжлийн банкны өмчлөлд шилжсэн 2 үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулахыг зөвшөөрөх тухай.
	Аудитын хорооны хурал	2023.11.28	Цахим	<ul style="list-style-type: none"> ДАГ-ын ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний загвар, ДАГ-ын 2023 оны 3-р улирлын аудитын ажлын нэгдсэн тайлан.
9	ТУЗ-н ээлжит бус хурал	2023.12.01	Цахим	<ul style="list-style-type: none"> Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл хүсэх тухай (Ти Ди Би Капитал ХХК); Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл хүсэх тухай (“Нэйшнл Ньюс Корпорэйшн” ХХК); Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл хүсэх тухай (“Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК); МАБЕЛ ХХК-ийн зээлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх тухай; Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмын төслийг танилцуулж, журам батлуулах тухай; Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх ажлын албаны бүтцэд өөрчлөлт оруулах, ТУЗДАА-ны үйл ажиллагааны журамд холбогдох өөрчлөлтийг оруулах тухай.
	ТУЗ-н ээлжит бус хурал	2023.12.14	Саналын хуудсаар	<ul style="list-style-type: none"> Зээлийн өр төлбөрт тооцон авч, Худалдаа, хөгжлийн банкны өмчлөлд шилжсэн үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулахыг зөвшөөрөх тухай; Худалдаа, хөгжлийн банкны өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулахыг зөвшөөрөх тухай.

10	ТУЗ-н ээлжит бус хурал	2023.12.20	Цахимаар	<ul style="list-style-type: none"> • Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл хүсэх тухай (Ти Ди Би Секьюритис ҮЦК ХХК); • Хөдлөх хөрөнгө худалдан борлуулах • зөвшөөрөл хүсэх тухай; • ХХБ-ны 2024 оны санхүүгийн зорилт, санхүүгийн төлөвлөгөөг танилцуулах батлуулах тухай.
11	ТУЗ-ийн ээлжит бус хурал	2023.12.27	Цахим	<ul style="list-style-type: none"> • Зээлийн эрсдэлийн болон авлагын эрсдэлийн сангаас зээл болон авлага хаах тухай;

Тэмдэглэл:

Тухайн улиралд хуралд оролцоходоо дараах чиглэлээр асуулт асуух, санал, зөвлөмж хэлэх, үүрэг даалгавар өгөх байдлаар ажиллалаа. Үүнд:

- *Банк IPO хийж ХК болсонтой холбогдуулан гарч буй дүрэм журам, тайлагналын өөрчлөлттэй танилцах, санал гаргах;*
- *Банкны бодлого, стратеги, төлөвлөлт хэрэгжилтийн асуудлаар;*
- *Банкны үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлагын чиглэлээр;*
- *Компанийн үйл ажиллагааны гүйцэтгэл, түүний хяналт, үнэлгээний асуудлаар;*
- *Дотоод аудитын үйл ажиллагаа, тайлагналыг сайжруулах хүрээнд;*

Тухайн хагас жилд банк ХК болж өөрчлөгдсөнтэй холбоотой шинээр мөрдөх дүрэм журамтай танилцах, өөрт хамаарал бүхий шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхтэй холбоотой шинэ ажлууд байснаас гадна аудитын хорооны бүрэлдэхүүн шинэчлэгдэж, ХК болсонтой холбогдуулан ДАГ, АХорооны үйл ажиллагаа, тайлагнал, үр дүнгийн хяналтыг сайжруулах тал дээр анхаарч ажиллалаа. Мөн банкны үйл ажиллагаа, стратеги, бизнесийн загварыг чиглэлд хийж буй өөрчлөлтүүдэд чиглэж ажиллав.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл

2023 оны 4-р улиралд дараах сонирхлын зөрчилтэй хэлцлүүдэ ТУЗ-н хурлаар орж хэлэлцэгдсэн, тухай бүрд хуралд оролцож өөрийн саналыг өгч оролцлоо. Үүнд:

- Худалдаа, хөгжлийн банкны холбогдох этгээд болох Си Эн Би Консалтинг ХХК-д Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулсан нөхцөл, “Кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу кастодианы үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрсөх тухай;
- Худалдаа, хөгжлийн банк болон Ти Ди Би Лизинг ХХК нарын хооронд байгуулсан 2013 оны 09-р сарын 23-ны өдрийн №А/198 тоот Эх үүсвэргүй аккредитив, баталгааны эрх нээх гэрээ, №ЗЭГ/198 тоот Зээлийн эрх нээх гэрээнүүдэд нөхцөлд өөрчлөлт оруулж, Ти Ди Би Лизинг ХХК-тай энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлтэй Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ, Эх үүсвэргүй аккредитив, баталгааны эрх нээх нэмэлт гэрээнүүдийг байгуулах тухай;
- Зээлийн өр төлбөрт тооцон авч, Худалдаа, хөгжлийн банкны өмчлөлд шилжсэн үл хөдлөх эд хөрөнгө болох Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 3 дугаар хороо, 5 хороолол /14252/, Усны гудамж, 27 байр 1/11 тоот хаягт байршилтай 165.17 м.кв талбайтай үйлчилгээний зориулалттай

эрхийн улсын бүртгэлийн Ү-2203049046 дугаар үл хөдлөх эд хөрөнгийг 1,090,000,000.00 (нэг тэрбум ерэн сая) төгрөг эсхүл түүнээс дээш үнээр худалдан борлуулж, Худалдаа, хөгжлийн банкны өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгөөс хасах тухай;

- Зээлийн өр төлбөрт тооцон авч, Худалдаа, хөгжлийн банкны өмчлөлд шилжсэн үл хөдлөх эд хөрөнгө болох Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, 5 хороолол /14251/, Чингисийн өргөн чөлөө гудамж, 8 дугаартай барилгын 3 дугаар давхар тоот хаягт байршилтай 518.51 м.кв талбайтай оффисын зориулалттай эрхийн улсын бүртгэлийн Ү2203019998 дугаартай үл хөдлөх эд хөрөнгийн зарим хэсгийг хэсэгчлэн энэхүү тогтоолын Хавсралтад заасан үнэ эсхүл түүнээс дээш үнээр худалдан борлуулж, Худалдаа, хөгжлийн банкны өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгөөс хасах тухай;
- Худалдаа, хөгжлийн банкны холбогдох этгээд болох Ти Ди Би Лизинг ХХК-тай энэхүү тогтоолын Хавсралтад заасан нөхцөлтэй “Байгууллагын бизнес кредит карт эзэмших гэрээ” байгуулах тухай;
- Худалдаа, хөгжлийн банкны холбогдох этгээд болох Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК-тай энэхүү тогтоолын Хавсралтад заасан нөхцөлтэй “Зээлийн эрх нээх гэрээ” байгуулах тухай;
- Худалдаа, хөгжлийн банк болон Ти Ди Би Капитал ХХК нарын хооронд байгуулсан 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн №ЗГ9101/181218 тоот “Зээлийн гэрээ”-ний нөхцөлд өөрчлөлт оруулж, Ти Ди Би Капитал ХХК-тай энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлтэй “Зээлийн нэмэлт гэрээ”-г байгуулах тухай;
- Худалдаа, хөгжлийн банк болон Нэйшнл Ньюс Корпорэйшн ХХК нарын хооронд 2022 оны 8 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан №ЗГ/СС220817007-1 тоот “Зээлийн гэрээ”-г энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлтэй “Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ”-гээр шинэчлэн өөрчилж байгуулах тухай;
- Худалдаа, хөгжлийн банкны холбогдох этгээд болох Ти Ди Би Секьюритис ҮЦК ХХК-тай Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан нөхцөлийн дагуу “Кастодианы үйлчилгээ үзүүлэх нэмэлт гэрээ” байгуулах

Дээрх сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хэлэлцэх явцад ТУЗ-н хараат бус гишүүний үүргийн хүрээнд хууль эрх зүйд нийцтэй байдал, Монголбанкны тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах байдал, комплайнсын хүрээнд нийцтэй зэргийг тодруулж, тайлбар авч ажиллалаа.

Бусад үйл ажиллагаа:

ТУЗ, хороодын хурал, сонирхлын зөрчилтэй хэлцлүүдэд санал өгөх ТУЗ-н хараат бус гишүүний үндсэн үүргээс гадна дараах бусад үйл ажиллагаанд оролцож ажиллалаа. Үүнд:

- Монголбанк болон бусад байгууллагын зүгээс шаардсан мэдээллийг гаргаж өгөх;
- Хувьцаа эзэмшигч, СБД-н 2-р хорооны иргэн Б.Зоригтбаатарын Монголбанкын ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд банкуудын ТУЗ-н хараат бус гишүүдийн тайлантай холбоотой гаргасан өргөдөлтэй танилцах;

ТУЗ, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Аудитын хорооны даргаар ажиллахдаа Компанийн хууль, Банкны тухай хууль, МБ-ны журам, ХХБ-ны дүрмийг мөрдлөг болгон банкны үйл ажиллагаатай холбоотой ТУЗ, Гүйцэтгэх Удирдлагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр нь банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэх, хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих, банкны

харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах зэрэг ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд хүлээх нэмэлт үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллахыг удирдлага болгосон болно.

Худалдаа Хөгжлийн Банкны

ТУЗ-ийн хараат бус гишүүн:



Ж.Дэлгэрсайхан

2024 оны 01 сарын 15

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Ж.БОЛОРМААГИЙН
2023 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо (ЦУНДХ)-ны гишүүн, дарга, Аудитын хороо (АХ)-ны гишүүнээр өнгөрсөн хугацаанд ажиллалаа.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл, ЦУНДХ, АХ-ны ээлжит болон ээлжит бус хурлуудад цахимаар, бичгээр санал өгөх аргаар оролцож, холбогдох асуудалд саналаа өгч ажилласан.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал дараах хугацаанд хуралдав.

- 1.1. 2023.07.06-ны өдөр
- 1.2. 2023.08.10-ны өдөр;
- 1.3. 2023.10.09-ний өдөр;
- 1.4. 2023.10.19-ний өдөр;
- 1.5. 2023.11.23-ны өдөр;
- 1.6. 2023.12.01-ний өдөр;
- 1.7. 2023.12.15-ны өдөр;
- 1.8. 2023.12.20-ны өдөр;
- 1.9. 2023.12.27-ны өдөр.

Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан, хараат бус гишүүний хувьд шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах төрлийн шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

1. ТУЗ-ийн дарга сонгох;
2. ТУЗ-ийн хороодын дарга, гишүүд, нарийн бичгийн даргыг сонгох;
3. Худалдаа, хөгжлийн банкны 2023 оны 3-р улирлын гүйцэтгэлтэй танилцах;
4. Худалдаа, хөгжлийн банкны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тайлантай танилцах;
5. Сонирхлын зөрчилтэй 6 хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
6. Худалдаа, хөгжлийн банкны Комплайнсын үйл ажиллагаатай холбоотой бодлого, журам, зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах;
7. Худалдаа, хөгжлийн банкны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай асуудлыг дахин судалж, танилцуулахыг үүрэг болгох;
8. Худалдаа, хөгжлийн банкны үндсэн хөрөнгө, БЗХ, ӨБХХ, ӨБҮХХ-д бүртгэлтэй хөрөнгүүдийг зарах зөвшөөрөл олгох;
9. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам батлах;
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх ажлын албаны бүтцэд, үйл ажиллагааны журамд өөрчлөлт оруулах;

11. Худалдаа, хөгжлийн банкны 2024 оны санхүүгийн төсөв батлах тухай;
12. Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэрлэх бусад асуудал.

Тайлант хугацаанд ЦУНДХ нь нийт 3 удаа хуралдаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмын төсөл болон ТУЗ-ийн дэргэдэх ажлын албаны бүтцэд, үйл ажиллагааны журамд өөрчлөлт оруулах асуудлыг ТУЗ-д танилцуулах зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 57 тоот тогтоолоор АХ-ны гишүүнээр сонгогдсоноос хойш тус хороо нь нийт 2 удаа хуралдаж, Худалдаа, хөгжлийн банкны 2023 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгох, Дотоод аудитын газрын 2023 оны 2 болон 3 дугаар улирлын аудитын ажлын нэгдсэн тайлантай танилцах, Дотоод аудитын газрын ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний загвартай танилцах зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлаас гарсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй санал байгаагүй бөгөөд хууль тогтоомжид нийцсэн шийдвэр гаргахад анхаарч, өөрийн саналаа өгч ажилласан.

Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд өөрийн саналаа тусгаж ажилласан. Тайлант хугацаанд буюу 2023 оны сүүлийн хагас жилд нийт 6 сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай асуудалд санал өгсөн бөгөөд зарчмын зөрүүтэй санал байгаагүй, энэхүү шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн шийдвэр байсан. Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэлтэй холбоотой асуудал ТУЗ-ийн хуралд танилцуулагдаагүй.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан гишүүний эрх, чиг үүргийн хүрээнд тайлант хугацаанд аливаа зөрчил, дутагдлыг арилгах, хяналт тавих хүрээнд тавьсан шаардлага байгаагүй ба хэлэлцсэн асуудлаар тавьсан саналыг ТУЗДАА болон Банкны удирдлага, газар нэгжүүд хүлээн авч тухай бүр засаж залруулж, хэрэгжүүлж явсан бөгөөд ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд хүлээх нэмэлт үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллахыг удирдлага болгосон болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн



Ж.Болормаа

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН З.НАРАНТУЯАГИЙН
2023 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн хараат бус гишүүн, 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, 2023 оны 8 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр тус тус ажиллаж байна.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурал, Эрсдэлийн удирдлагын хороо, Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны дараах хурлуудад оролцож, холбогдох шийдвэрүүд гаргахад саналаа өгч ажилласан.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

- 1.1. 2023.07.06-ны өдөр
- 1.2. 2023.08.10-ны өдөр;
- 1.3. 2023.10.09-ний өдөр;
- 1.4. 2023.11.23-ны өдөр;
- 1.5. 2023.12.01-ний өдөр;
- 1.6. 2023.12.15-ны өдөр;
- 1.7. 2023.12.20-ны өдөр;
- 1.8. 2023.12.27-ны өдөр.

2. Эрсдэлийн удирдлагын хорооны хурал

- 2.1. 2023.08.04-ний өдөр;
- 2.2. 2023.10.04-ний өдөр;
- 2.3. 2023.10.23-ны өдөр.

3. Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны хурал

- 3.1. 2023.10.06-ны өдөр;
- 3.2. 2023.11.29-ний өдөр.

Энэхүү хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах төрлийн шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

ТУЗ-ийн хурлаар:

1. ТУЗ-ийн тогтоолд өөрчлөлт оруулах;
2. ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн хороодын бүрэлдэхүүнийг батлах;
3. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг зөвшөөрөх эсэх хүсэлтийг шийдвэрлэх;

4. Худалдаа, хөгжлийн банкны Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой бодлого, журам, зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах;
5. Худалдаа, хөгжлийн банкны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай асуудлыг дахин судалж, танилцуулахыг үүрэг болгож буцаах;
6. Худалдаа, хөгжлийн банкны үндсэн хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгө, өмчлөх бусад хөрөнгөд бүртгэлтэй хөдлөх болон үл хөдлөх хөрөнгүүдийн зах зээлийн үнийг тогтоож, худалдан борлуулах зөвшөөрөл олгох;
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмыг батлах;
8. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх ажлын албаны бүтцэд өөрчлөлт оруулах, ТУЗДАА-ны үйл ажиллагааны журамд холбогдох өөрчлөлтийг оруулах;
9. Худалдаа, хөгжлийн банкны 2024 оны санхүүгийн төсөв батлах тухай;
10. Зээлийн болон авлагын эрсдэлийн сангаас зээл, авлага хаах зөвшөөрөл олгох.

Эрсдэлийн удирдлагын хорооны хурлаар:

1. Худалдаа, хөгжлийн банкны Комплайнсын холбогдолтой дараах бодлого, журмуудад өөрчлөлт оруулах асуудлыг дэмжсэн саналтайгаар ТУЗ-ийн хуралд танилцуулах;
2. Худалдаа хөгжлийн банкны 2023 оны Чанаргүй зээлийг бууруулах стратеги болон Эрсдэлийн аппетитын 2 болон 3 дугаар улирлын гүйцэтгэлтэй танилцсан.

Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны хурлаар:

1. Худалдаа, хөгжлийн банкны бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай асуудлыг дахин судалж, танилцуулахыг үүрэг болгох саналтайгаар ТУЗ-д танилцуулах;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмын төслийг дэмжсэн саналтайгаар ТУЗ-д танилцуулах;
3. ТУЗ-ийн дэргэдэх ажлын албаны бүтцэд өөрчлөлт оруулах, түүний үйл ажиллагааны журамд холбогдох өөрчлөлтийг оруулах асуудлыг дэмжсэн саналтайгаар ТУЗ-д танилцуулах.

Дээр дурдсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй санал байгаагүй бөгөөд хууль тогтоомжид нийцсэн шийдвэрүүд байсан гэж үзэж байна.

Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд өөрийн саналаа тусгаж ажилласан. Тайлант хугацаанд зургаан сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрөл хүссэн асуудалд санал өгсөн бөгөөд зарчмын зөрүүтэй санал байгаагүй, энэхүү шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн

шийдвэр байсан. Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэлтэй холбоотой асуудал ТУЗ-ийн хурлаар хэлэлцэгдээгүй.

ТУЗ түүний дэргэдэх хороодын дарга, гишүүнээр ажиллахдаа төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь улс төрийн, том хувь нийлүүлэгчдийн нөлөөлөл болон бусад гаднын зохисгүй нөлөөнөөс үл хамааран Худалдаа, хөгжлийн банкны эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавьж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Банкны үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч Банк болон хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэн ажиллахыг удирдлага болгосон болно.

Худалдаа, хөгжлийн банкны
ТУЗ-ийн хараат бус гишүүн



З.Нарантуяа